



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар

А/701

Ховд

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Засгийн газраас гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасантай холбогдуулан Ховд аймгийн нутаг дэвсгэрээс орох, гарах нийтийн болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласан Ховд аймгийн Засаг даргын 2020 оны А/688 дугаар захирамжийн хэрэгжилтийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08:00 цаг хүртэл сунгасугай.

2. Нийтийн тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Жаргалант сумын Засаг дарга бөгөөд Ховд хотын захирагч /С.Гантөмөр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын пост, цэгүүдийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үүрэг гүйцэтгэж байгаа мэргэжлийн байгууллагуудын алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, хоол хүнс, аюулгүй байдлыг хангуулах заавар зөвлөмж өгч ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Ховд хотын

захирагч бөгөөд Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДУГЭРЖАВ

